

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 5 дугаар
сарын 27-ны өдөр

№ 05/01

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга томилох тухай


Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, 78.2 дахь хэсэг, “Инновэйшн Инвестмент” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Компанийн засаглалын кодексын шинэчилсэн найруулга”-ын холбогдох хэсэг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 02/17 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар сайшаан батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн **Адилбиш** овогтой **Баттамир** -г томилсугай.
2. **А.Баттамир**-г Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавихыг үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга томилогдсонтой холбоотойгоор компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд үр ашигтай бөгөөд зохистойгоор удирдан явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга томилогдсонтой холбогдуулан холбогдох мэдээллийн өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Эрдэнэмөнх)-д үүрэг болгосугай.


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.АНХБОЛД



 / (гарын үсэг)


А.БАТТАМИР

 / (гарын үсэг)

Б.ЧУЛУУНСҮХ

 / (гарын үсэг)


Г.ХАТАНБОЛД

 / / (гарын үсэг)

У.МӨНХЗУЛ

 / / (гарын үсэг)

У.НАРАНБААТАР

 / / (гарын үсэг)


Д.ГАНЗОРИГ

 / / (гарын үсэг)

Т.ДАШЦЭРЭН

 / / (гарын үсэг)

Ш.УЯНГА

 / / (гарын үсэг)